



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/374

Хэрлэн сум

**Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
худалдан авах ажиллагааг зохион байгуулах  
үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлах хогийн цэгийг булж даршлах (шинээр хогийн цэг үүсгэх, 4-5-р цэгийг булшлах) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Мөнхжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичиг: С.Тэмүүжин Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Гишүүд: Д.Оюун Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ